

# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 12 сарын 25

№ 23/02

Улаанбаатар хот

## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### КОМПАНИЙН БҮРТГЭЛТЭЙ ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 2023 оны 12 сарын 25-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн бүртгэлтэй хаягийг **“Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар”** болгон өөрчилсүгэй.
2. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусган дүрмийн шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор баталсугай.
3. Компанийн бүртгэлтэй хаягийг орон нутгаас Улаанбаатар хот дахь хаягт шилжүүлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.УЯНГА



# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 12 сарын 25

№ 23/03

Улаанбаатар хот

## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2023 оны 12 сарын 25-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах үйл ажиллагаа эрхлэхээр болгон өөрчилсүгэй:
  1. **Менежментийн зөвлөгөө өгөх**
2. Компанийн эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхтэй холбоотойгоор дараах үйл ажиллагааны чиглэлийг хассугай:
  1. Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх
  2. Модон эдлэл үйлдвэрлэх засварлах
  3. Гэрийн мод үйлдвэрлэл
  4. Төрөлжсөн бус барааны бөөний худалдаа
3. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр шинэчлэн баталсугай.
4. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд орсон өөрчлөлтийг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.УЯНГА



# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 12 сарын 25

№ 23/04

Улаанбаатар хот

## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2023 оны 12 сарын 25-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажилд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.УЯНГА



# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 12 сарын 25

№ 23/05

Улаанбаатар хот


## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### КОМПАНИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ШИНЭЭР АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2023 оны 12 сарын 25-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн бүртгэлтэй хаягийг орон нутгаас Улаанбаатар хот дахь хаягт шилжүүлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА \_\_\_\_\_ Г.УЯНГА



# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 12 сарын 25

№ 23/06

Улаанбаатар хот

## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### САНХҮҮЖИЛГ АВАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11, 62.1.10 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.3, 92.3.1 дэх хэсэг, 2023 оны 12 сарын 25-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийг хоронгөжүүлэх, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Ард Санхүүгийн Нэгдэл ХК-аас 17,036,000,000 (арван долоон тэрбум гучин зургаан сая) тогрөг хүртэлх хэмжээний санхүүжилтийг 1 жилийн хугацаатай, эргэн толох нөхцөлтэйгөөр авах хэлцэл хийх зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Санхүүжилтийн эргэн тололтийн хуваарь, зээлийн хоронгийг шилжүүлэн авах нарийвчилсан нөхцөл журмыг санхүүжүүлэгч талтай тохиролцож, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, шийдвэр гаргаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.
3. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчийн шаардлагаар Компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авах журмыг баталж, хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.
4. Энэ тогтоолд заасны дагуу авсан зээлийн хоронгийг зориулалтын дагуу захиран зарцуулахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА



# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 12 сарын 25

№ 23/07

Улаанбаатар хот

## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11, 62.1.10 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.3, 92.3.1 дэх хэсэг, 2023 оны 12 сарын 25-ны өдрийн 23/02 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн авах санхүүжилтийн эх үүсвэрээр Тогтоолын Хавсралт 1-г заасан нэр бүхий хуулийн этгээдэд хөрөнгө оруулалт хийж, тогтоосон тоо хэмжээний дотор тус компаниудын хувьцааг худалдан авах хэлцэл хийх зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан компаниудын хувьцааг хуульд заасан журмын дагуу худалдан авах, хувьцааг худалдан авахтай холбоотой гэрээ байгуулах, хөрөнгө шилжүүлэх нохиол, журмыг тодорхойлох, тохиролцох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
3. Компанийн худалдан авах нийт хөрөнгийн хэмжээ нь түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийн хэмжээнээс хэтрэхгүй байхаар холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, худалдан авсан хувьцаанд хамаарах омчлох эрхийг бүртгүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
4. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчийн шаардлагаар Компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авах журмыг баталж, хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  УЯНГА

